



**ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2026 оны 03 сарын 09 өдөр

Дугаар А/22

Баян-Өндөр сум

Хөтөлбөр шинэчлэн батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дах заалт, Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/379 дугаар тушаал, Орхон аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 02/16 дугаар тогтлоор батлагдсан “Хүн амын бүлгүүд, Нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн газрын албан хаагчдын “Нийгмийн баталгаа” хөтөлбөрийг нэгдүгээр хавсралтаар, “Сургалт” хөтөлбөрийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Эрүүл мэндийн газрын албан хаагчдын “Нийгмийн баталгаа” болон “Сургалт” хөтөлбөрүүдийн төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Салбарын хүний нөөцийн төлөвлөлт хангалт, сургалт, нийгмийн асуудал хариуцсан мэргэжилтэн (Б.Ариунжаргал)-д үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Удирдлага төлөвлөлтийн хэлтсийн Бодлого төлөвлөлт, хууль эрх зүй, тусгай зөвшөөрөл хариуцсан ахлах мэргэжилтэн (Б.Уртнасан)-д даалгасугай.

ДАРГА



Ц.МӨНХЦЭЦЭГ

Эрүүл мэндийн газрын даргын 2026 оны  
03 сарын 03 -ний өдрийн 1/21 тоот  
тушаалын нэгдүгээр хавсралт



ОРХОН АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН АЖИЛЧДИЙН  
“НИЙГМИЙН БАТАЛГАА” ХӨТӨЛБӨР

**Нэг. Нийтлэл үндэслэл**

Монгол улсын Төрийн албаны тухай хуулийн 55.3 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/379 дугаар тушаал, Орхон аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 02/16 дугаар тогтлоор батлагдсан “Хүн амын бүлгүүд, Нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийг тус тус үндэслэл болгон Орхон аймгийн Эрүүл мэндийн газрын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааны хөтөлбөр (цаашид хөтөлбөр гэх)-ийг боловсруулав.

**Хоёр. Хөтөлбөрийн зорилго, зорилт, хугацаа**

2.1 Орхон аймгийн Эрүүл мэндийн газрын албан хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах, тэдний нийгмийн баталгааг хангахад энэхүү хөтөлбөрийн зорилго оршино.

2.2 Хөтөлбөрийг хэрэгжүүлэхээр дараах зорилтуудыг дэвшүүлж байна.

2.2.1 Төрийн албан хаагчдын ажлын байрны хөдөлмөрийн эрүүл ахуй, аюулгүй байдлыг хангах нөхцөлийг бүрдүүлэх

2.2.2 Төрийн албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, эрүүлжүүлэх

2.2.3 Төрийн албан хаагчдын амьдралын түвшинг нэмэгдүүлэх

2.2.4 Төрийн албан хаагчдын амралт, чөлөөлт цагийг зөв, үр дүнтэй өнгөрүүлэх

2.3 Хөтөлбөрийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2030 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд хэрэгжүүлнэ.

**Гурав. Ажиллах нөхцөл, ажлын байрны баталгаа**

3.1 Төрийн албан хаагчийн орон тоо, албан тушаалыг дараах хугацаанд хадгалах ба урьд ажиллаж байсан түвшнээс бууруулахгүй ажлын байраар хангана:

3.1.1 Төрийн албан хаагч мэргэшүүлэх сургалтад суралцах хугацаанд;

3.1.2 Эмчилгээ, оношлогоо хийлгэх, эмчлүүлэх, эмчийн магадлагаагаар болон захиргааны чөлөөтэй байх;

3.1.3 Хөдөлмөрийн чадвараа түр алдаж байгаад эргэж ажилдаа орох хүртэл;

3.2 Төрийн албан хаагч нь Төрийн албаны тухай хууль болон шүүхийн хүчин төгөлдөр шийдвэр гарснаас бусад тохиолдолд төрийн албанаас халагдахгүй байх баталгаа эдэлнэ.

3.3 Ажлын үр дүнгээр мөнгөн шагналаар шат дараалан шагнах ба Засгийн газар, төрийн дээд шагнал, одон медалиар шагнуулах, цол олгуулахаар тодорхойлно. Төрийн бусад байгууллагын шагналд тодорхойлно.

3.4 Эрхэлсэн ажилдаа үр бүтээлтэй ажиллаж, мэргэжлийн ур чадвараа дээшлүүлэн тодорхой амжилт гаргаж байгаа төрийн албан хаагчдад шатлан дэвших бололцоог олгоно.

3.5 Төрийн захиргааны албан хаагчийн тангараг өргөсөн төрийн жинхэнэ албан хаагчдад зэрэг дэв олгох, ахиулах асуудлыг тухай бүр шийдвэрлүүлж байна.

#### **Дөрөв. Цалин хөлсний баталгаа**

4.1 Төрийн албан хаагчдад батлагдсан сүлжээний дагуу албан тушаалын ангилал, зэрэглэлд тохирсон цалин, хөлсийг сар бүр олгоно.

4.2 Албан хаагч бүрийн албан тушаалын тодорхойлолт, гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан ажил үүрэг, тухайн ажлын байранд тавигдах шаардлагыг ханган биелүүлсэн, гүйцэтгэсэн ажлын тоо хэмжээ, чанар, жилд ажилласан хоногийн байдлыг харгалзан урамшуулал олгоно.

4.3 Зохих удирдлагын шийдвэрээр илүү цагаар болон амралт баяр ёслолын өдөр ажилласан албан хаагчдыг нөхөн амруулаагүй тохиолдолд илүү цагийн хөлсийг Хөдөлмөрийн тухай хууль, тогтоомжийн дагуу нэмэгдүүлсэн үнэлгээгээр тооцон олгоно.

4.4 Цалин хөлс, нэмэгдэл олгохтой холбогдсон дүрэм, журмыг ил тод байлгаж албан хаагч бүрт танилцах боломжоор хангана.

4.5 Төрийн албан хаагч нэг бүр нийгмийн даатгалын шимтгэл, эрүүл мэндийн даатгалын хураамж, тэдгээрийн бичилт, хүн амын орлогын албан татварын хураалт болон бусад суутгалын талаар танилцах, хяналт тавих боломжоор хангана.

4.6 Цалин хөлсийг сард 1-2 удаа хувааж олгоно.

#### **Тав. Эрүүл мэндийн баталгаа**

5.1 Нийт албан хаагчдыг эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт жил бүр хамруулна.

5.2 Эрүүл мэндийн байдлаас шалтгаалан 2 болон 3 дах шатлалын эмнэлэгт онош тодруулах, шинжилгээ хийлгэхэд Хөдөлмөрийн дотоод журамтай уялдуулан цалинтай чөлөө олгоно.

5.3 Гадаад, дотоодод урт хугацаагаар эмчлүүлэх тохиолдолд албан хаагчдад байгууллагын санхүүгийн нөөц боломжид тулгуурлан мөнгөн дэмжлэг үзүүлнэ.

5.4 Албан хаагчдыг биеийн тамир, спортоор хичээллэх нөхцөл боломжоор хангана.

#### **Зургаа. Ажиллах нөхцөлийн баталгаа**

6.1 Байгууллагын удирдлага хөдөлмөр хамгааллын хууль, тогтоомжийн хүрээнд албан хаагчдын хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөлийг хангана. Үүнд: албан тасалгааны нормативт талбай, ариун цэвэр, тохижилт, агааржуулалт, дулаан, гэрэлтүүлэг зэрэг багтана.

6.2 Төрийн албан хаагчид албан үүргээ шаардлагын дагуу гүйцэтгэх нөхцөл, бололцоог бүрэн хангасан тавилга, бичгийн болон бусад техник хэрэгсэл, программ хангамжаар хангана.

6.3 Албан хаагчдын ажлын хэрэгцээнд зориулан өдөр тутмын голлох сонин, сэтгүүлийг байгууллагаас захиалан уншиж, танилцах боломжоор хангахын дээр мэргэжлийн болон шинэ номоор үйлчилнэ.

6.4 Эрүүл ахуйн шаардлага хангасан халуун ба хүйтэн усаар байнга хангана.

#### **Долоо. Амьдралын түвшний баталгаа**

7.1 Олон хүүхэдтэй (4-өөс дээш) эмэгтэйчүүд болон өрх толгойлсон, гэрт буюу галладаг байранд амьдардаг албан хаагчдад амьдралын түвшинг харгалзан хүйтний улиралд түлшний зардалд зориулан мөнгөн дэмжлэг үзүүлнэ. Дотоод журмын дагуу албан хаагчдад 2 жил тутамд түлшний дэмжлэг үзүүлнэ.

7.2 Албан хаагчдыг хууль тогтоомжоор хориглоогүй ажил хөдөлмөр, аж ахуй эрхлэх, газар тариалан эрхлэх, хичээл заах, эрдэм судалгааны ажил эрхлэх, бүтээл туурвихад нь дэмжлэг үзүүлнэ.

7.3 Тэтгэвэрт гарч буй албан хаагчдад 36 хүртэл сарын цалинтай тэнцэх хэмжээний тэтгэмжийг нэг удаа олгоно.

#### **Найм. Амрах эрхийн баталгаа**

8.1 Албан хаагчдын санал болон ажлын шаардлагыг харгалзан жил бүрийн эхэнд ээлжийн амралтын хуваарийг баталж, хуваарийн дагуу ээлжийн амралтыг биеэр эдлүүлэх ажлыг зохион байгуулна.

8.3 Эх орны түүх соёлын дурсгалт газруудаар хийх аяллыг жил бүр зохион байгуулна.

8.4 Байгаль орчинтой танилцах, эрүүл агаарт гарч идэвхтэй амрах ажлыг жилд 1-2 удаа зохион байгуулна.

8.5 Хууль, тогтоомжоор тогтоосон баяр ёслол, тэмдэглэлт өдрүүдээр ажилласан тохиолдолд нөхөн амраана. Амраагүй тохиолдолд нөхөн олговрыг хуулийн дагуу олгоно.

#### **Ес. Сурч боловсрох эрхийн баталгаа**

9.1 Албан хаагчдыг мэргэшүүлэх, мэргэжил дээшлүүлэх хугацаанд ажлын байрыг 1 хүртэл жилийн хугацаанд хадгална.

#### **Арав. Бусад баталгаа**

10.1 Албан хаагчдын амьдралд онцлох үйл явдал болон гачигдал тохиолдсон үед Хөдөлмөрийн дотоод журамд заасан цалинтай чөлөө олгоно.

10.2 Албан хаагчдад гачигдал тохиолдоход Хөдөлмөрийн дотоод журамд заасан тусламж, тэтгэмжээс гадна хамт олны зүгээс тусламж үзүүлнэ.

## **Арван нэг. Хөтөлбөрийн хэрэгжилтийн удирдлага, зохион байгуулалт**

11.1 Хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлыг Эрүүл мэндийн газрын Салбарын хүний нөөцийн төлөвлөлт хангалт сургалт, нийгмийн асуудал хариусан мэргэжилтэн хариуцна.

11.2 Энэхүү хөтөлбөрт тусгагдсан зорилт, арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг төсөвт жил болгон тусган батлуулж байна.

11.3 Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц байдлыг жил бүр дүгнэж, хамт олны хурлаар хэлэлцүүлнэ.

11.4 Хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, хууль эрх зүйн өөрчлөлт, үр дүнгээс шалтгаалан нэмэлт, өөрчлөлт оруулж болно. Нэмэлт өөрчлөлт оруулахдаа хөтөлбөрт тусгагдсан баталгааг дордуулахгүй байх зарчмыг баримтална.

### **Арван хоёр.Хөтөлбөрийг хэрэгжүүлсний үр дүн**

12.1 Энэ хөтөлбөрийг хэрэгжүүлснээр төрийн албан хаагчдын хөдөлмөрлөх эрх, түүнтэй холбоотой хууль, тогтоомжоор тогтоосон баталгааг эдлүүлэх бололцоог бүрдүүлэх төдийгүй хууль, тогтоомжоор шууд зохицуулагдаагүй эрх ашиг, сонирхолд нийцсэн зарим үйл ажиллагааг зохицуулан хэрэгжүүлэх эрх зүйн үндэс болно.

12.2 Төрийн албан хаагчдын ирээдүйдээ итгэх итгэл батжин, ажлын идэвх нэмэгдсэнээр тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллах нөхцөл бүрдэнэ.

12.3 Хамт олон нягтран төлөвшиж, төрийн албаны мэргэшсэн, чадварлаг баг хамт олон бүрдэнэ.

Эрүүл мэндийн газрын даргын 2026 оны  
03 сарын 09 ний өдрийн 152-тоот  
тушаалын хоёр дугаар хавсралт



## ОРХОН АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН АЖИЛЧДЫН “СУРГАЛТ” ХӨТӨЛБӨР

### Нэг. Нийтлэл үндэслэл

Монгол Улсын төрийн захиргаа, төрийн албаны өөрчлөлт, шинэчлэл нь төрийн захиргааны бүх шатны байгууллагын өмнө шинэ зорилт, чиг үүргийг мэдлэг чадвартай төрийн албан хаагчдын оролцоотойгоор хэрэгжүүлж, иргэдэд чанар сайтай төрийн үйлчилгээ үзүүлэх шаардлага, хариуцлагын шинэ тогтолцоог бий болгож байна.

Төрийн албан хаагчийн үр нөлөө, үр ашигтай ажиллах нэгэн нөхцөл баталгаа нь түүнийг хөгжүүлэх, төрийн албаны сургалтад хамруулан чадавхыг дээшлүүлэх явдал юм.

Засгийн газрын 1999 оны 96 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны сургалт ба мэдлэг чадвар бий болгох хөтөлбөр”, Эрүүл мэндийн сайдын 2025 оны А/379 дугаар тушаал, Орхон аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2025 оны 02/16 дугаар тогтоолоор батлагдсан “Хүн амын бүлгүүд, Нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр”-ийг тус тус үндэслэн боловсруулсан болно.

### Хоёр. Хөтөлбөрийн зорилго

2.1 Хөтөлбөрийн зорилго нь Эрүүл мэндийн газрын албан хаагчдыг мэргэшүүлэх, чадваржуулах, мэдлэг чадвар бий болгоход оршино.

### Гурав. Хөтөлбөрийн зорилт

3.1 Төрийн албан хаагчдыг сургаж хөгжүүлэх замаар байгууллагыг хөгжүүлэх

3.2 Төрийн албан хаагчдыг мэргэшүүлж, тогтвор суурьшилтай ажиллуулах

3.3 Төрийн албан хаагч нь эрхэлсэн ажил, албан үүргээ амжилттай гүйцэтгэх мэдлэг, мэдээлэл олж авах, онол арга зүй, ур чадвар эзэмших

### Дөрөв. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх стратеги

4.1 Үйл ажиллагааны чадавх сайтай байгууллага байх

4.2 Улс, аймаг, олон улсад өрсөлдөх чадвартай, мэргэшсэн төрийн албан хаагчтай болох

4.3 Эрүүл мэндийн газар суралцагч байгууллага болсон байх

4.4 Албан хаагчдын манлайлал ба оролцооны түвшинг хангах

### Тав. Хөтөлбөрийг хэрэгжүүлэх хугацаа

5.1 Хөтөлбөрийг 2026 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2030 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэл хэрэгжүүлнэ.

## **Зургаа.Төрийн албан хаагчийн сургалт хөтөлбөрийн бодлого**

### **6.1 Үндсэн зарчим, үнэт зүйлс**

Төрийн албан хаагч нь Эрүүл мэндийн газрын хамгийн чухал, үнэт зүйл нөөц мөн. Иймд төрийн албан хаагчийн мэдлэг чадварыг бий болгох аливаа арга хэмжээг хөрөнгө оруулалт гэж үзнэ. Сургалтын хөтөлбөрийн бодлогыг тодорхойлоход дор дурдсан үндсэн зарчим ба үнэт зүйлсийг баримтална.

- 6.1.1 Төрийн албан хаагчдыг сургаж, төрийн байгууллагад мэдлэг чадвар бий болгох нь төрийн албаны ардчиллын үнэт зүйлсийг бэхжүүлнэ. Иймд мэдлэг чадвар бий болгох үйл явцыг түүнд оролцох хувийн санаачилга гаргах, өргөн боломжийг хангасан ардчилсан замаар хэрэгжүүлнэ.
- 6.1.2 Мэдлэг бий болгохдоо зах зээлийн, эдийн засгийн орчны өөрчлөлтийг харгалзан үзнэ. Эрүүл мэндийн газрын мэдлэг, чадвар бий болгох үйл явцад хувийн хэвшлийн мэргэжлийн байгууллагуудыг оролцуулан бололцоотой бүх нөөцийг ашиглана.
- 6.1.3 Мэдлэг чадвар бий болгох нь Эрүүл мэндийн газрын үйл ажиллагааны үр ашиг, үр нөлөөг дээшлүүлнэ. Хөрөнгийн эх үүсвэр хязгаарлагдмал тул сургалтын болон мэдлэг чадвар бий болгох үйл явцыг өртөг зардал хямдтайгаар хэрэгжүүлэхийг чухалчилна.
- 6.1.4 Эрүүл мэндийн газрын мэдлэг чадвар бий болгох үйл явцыг нээлттэй, ил тод байдлаар хэрэгжүүлнэ. Мэдлэг чадвар бий болгох үйл ажиллагаа нь тодорхой заагласан үүрэг хариуцлагын тогтолцоотой байна.
- 6.1.5 Яс, үндэс, нийгмийн гарал, хэл, арьс өнгө, нас хүйс, албан тушаал болон үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхахгүйгээр сургалтад оролцох боломжийг хүн бүрт олгоно.
- 6.1.6 Эрүүл мэндийн газрын удирдлага нь төрийн албан хаагчийг сургах, давтан сургахад санаачилга гаргах, чадавх бий болгох санаачилгыг урамшуулан дэмжих үүрэг хүлээнэ. Эрүүл мэндийн газрын бүх албан хаагч өөрсдийн мэдлэг чадварыг дээшлүүлэх, бусад албан хаагчдын мэдлэг чадварыг дээшлүүлэхэд дэмжлэг үзүүлэх үүрэг хүлээнэ.

### **6.2 Сургалтын талаар баримтлах бодлого**

#### **6.2.1 Мэдлэг чадвар бий болгох талаар баримтлах бодлого**

Эрүүл мэндийн газрын хэмжээнд мэдлэг чадварыг төрөл бүрийн өргөн хүрээтэй хандлагыг чухалчилж, төрийн албан хаагчдад мэдлэг чадварыг өдөр тутмын ажлын явцад болон зохион байгуулалттай сургалтын хэлбэрийг бий болгоно.

Сургалт нь:

1. Дотоод сургалт
2. Гадаад сургалт
3. Ажлын байран дахь сургалт гэсэн төрөлтэй байна.

Гадаад сургалтад дараах шаардлага тавигдана.

- Гадаад хэлний мэдлэгийн зохих түвшин
- Ажилласан хугацаа ажлын үр дүн

- Одоо эрхэлж байгаа ажлын чиг үүрэг нь сургалтын хөтөлбөртэй нийцэж буй эсэх

### **6.2.2 Ажлын байранд мэдлэг чадвар бий болгох талаар баримтлах бодлого**

Эрүүл мэндийн газрын хэмжээнд суралцагч орчин бүрдүүлснээр суралцах нь төрийн албан хаагчийн өдөр тутмын үйл ажиллагааны нэг хэсэг болно.

Суралцахад шаардлагатай цаг хугацааны хүчин зүйлийг харгалзан үзнэ. Төрийн албан хаагчид хоорондоо шүүн хэлэлцэх, мэдлэг мэдээллээ солилцох, түүнчлэн шинэ санаа, шийдэлд хүрэхэд шаардагдах цаг хугацааг үүнд хамруулна. Байгууллагын дотор багаар ажиллах, өдөр тутмын уулзалт, төслийн ажил, шийдвэрлэх асуудалд тулгуурлан суралцах, шавилан суралцах суралцагчийн хөтөлбөр, ажил сэлгүүлэн ажиллуулах зэргээр сургалтын оролцооны аргыг хөгжүүлнэ.

#### **Долоо. Сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагаа**

Эрүүл мэндийн газрын хэмжээнд төрийн албан хаагчдад сургалт явуулахдаа сургалтын хэрэгцээг тодорхойлох, сургалтын хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах, сургалт явуулах, сургалтын үнэлгээ зэрэг хүчин зүйлүүдийг зөв зохистой төлөвлөн биелэлтийг хангаж, төрийн албаны сургалтын агуулгад онолын мэдлэг олгох чиглэл давамгайлж байгааг өөрчилж онол практикийн оновчтой хослолыг бий болгоход чиглүүлж ажиллана.

7.1 Удирдлагын академид Засгийн газрын захиалгын дагуу зохион байгуулах, сургалт судалгааны ажлын төлөвлөгөөнд тусгагдсан сургалтад төрийн захиргааны албан хаагчдыг хамруулах ажлыг жил бүр зохион байгуулна.

7.2 Мэдлэг туршлагатай албан хаагчдыг шинээр ажилд авахад болон албан тушаалын ангилал, зэрэглэл ахих, өөр албан тушаалд шилжихэд тухайн шинэ орчин нөхцөлд шаардагдах мэдлэг, арга барил эзэмшүүлэх зорилгоор 1-3 долоо хоногийн зорилтот сургалтыг холбогдох сургалтын байгууллагад захиалах буюу өөрийн байгууллагын багшлах боловсон хүчнийг түшиглэн зохион байгуулна.

7.3 Мэдлэг, туршлагатай албан хаагчдыг дагалдуулан сургах өөрийгөө хөгжүүлэх, төлөвлөгөө хөтөлбөртэй ажиллуулах, ажил албан тушаал сэлгүүлэн ажиллуулах зэргээр ажлын байранд сургах сургалтыг жил жилээр төлөвлөн хэрэгжүүлнэ.

7.4 Эрүүл мэндийн газрын төрийн албан хаагчдаа сургах жил тутмын төлөвлөгөөнд ажлаас хөндийрүүлэхгүйгээр богино хугацааны сургалтад суралцуулна.

#### **Найм. Хөтөлбөрийн санхүүжилт**

- 8.1 Эрүүл мэндийг дэвмжих төвийн /төрийн сангийн зардал/
- 8.2 Аймгийн санхүүгийн дэмжлэг
- 8.3 Эрүүл мэндийн газрын төсөв
- 8.4 Албан хаагчдын хувийн зардал

## Ес.Хөтөлбөрийн үр дүн

Хөтөлбөрийг хэрэгжүүлснээр дараах үр дүнд хүрнэ.

9.1 Эрүүл мэндийн газрын хэмжээнд сургалтын хэрэгцээгээ удирдлага, төрийн албан хаагч хамтран тодорхойлдог болно.

9.2 Сургалтын агуулгыг байгууллагын суралцагчийн хэрэгцээнд тулгуурлан боловсруулдаг арга зүйд шилжинэ.

9.3 Хувь хүний мэдлэг чадвар, туршлагыг байгууллагын мэдлэг, чадвар туршлага болгон хөгжүүлнэ.

9.4 Байгууллагын дотоод нөөцийг ашиглан ажлын байран дахь сургалтыг хөгжүүлнэ.

9.5 Шинэ мэдлэг туршлага бий болсноор сайн үйл ажиллагааг төлөвшүүлж иргэдэд төрийн үйлчилгээг чанартай шуурхай хүргэнэ.

9.6 Төрийн албан хаагчдыг дотооддоо сургах чадавх бий болгохоос гадна гадаад сургалтыг өргөжүүлнэ.